



ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/05

Өмнөдэлгэр сум

「 Биеийн тамирын заал ашиглалтын журам 」 батлах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 39 дүгээр зүйлийн 39.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, Сургуулийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.4, 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.3.3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өмнөдэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн “Биеийн тамирын заал ашиглалтын журам”-ыг хавсралтаар баталж 2025 оны 01 дүгээр дугаар сарын 02-ны өдрөөр тооцон үйл ажиллагаанд дагаж мөрдсүгэй.

2. “Биеийн тамирын заал ашиглалтын журам”-ын дагуу биеийн тамирын зааланд төлбөртэй болон төлбөргүй явагдах сургалт, тоглолтын цагийн хуваарийг батлуулж, хамтран ажиллах байгууллагатай гэрээ байгуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг биеийн тамирын багш (Д.Мөнхчулуун, Б.Ганхуяг, Д.Мөнхцэцэг, О.Наранбаяр), биеийн тамирын заалны үйлчилгээний орлогыг хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих үүргийг нягтлан бодогч (М.Алтантуяа), нярав (Д.Даваасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Журам, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт шалгалтын багийн ахлагч (Э.Хэрлэн)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.СУГАРРАГЧАА